



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар Б/30

Чингис хот

**Ж.Цэнджавыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.1.6, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2, 2.4, 2.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл хүүхэд залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтнийг ажилдаа эргэн орох хүртэл хугацаанд уг албан үүргийг Эрүүл мэнд, нийгмийн даатгал, жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн Жамаадоржийн Цэнджавд түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Хүн ам зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл хүүхэд залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа Ж.Цэнджавд тухайн албан тушаалын цалингийн 20 хувийн цалин, урамшуулал олгосугай.

3. Урамшууллыг 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхэлж тооцон олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР